



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/051/НА-СТА-ТХН

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот</p> <p>2025 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Э.Энхбаатар Утас: 261885 Цахим хаяг: enkhbaatar.e@audit.mn</p> <p>Ахлах аудитор: Г.Мөнхчимэг Утас: 261740 Цахим хаяг: munkhchimeg.g@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Сүлд-Аудит" ХХК-ийн захирал: Ч.Гүндбаяр Утас: 70118016 Цахим хаяг: info@suld-audit.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ХОРШООЛСОН ХЭЛБЭРЭЭР
НОГООНЫ АЖ АХУЙ ЭРХЛЭХ ЗАМААР
ӨРХИЙН АМЬЖИРГААГ САЙЖРУУЛАХ
ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Б.БҮРЭНЖАРГАЛ ТАНАА

2025.03.17 № 07/1082
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төслийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Дархан-Уул аймгийн Орхон суманд 150 тонны багтаамжтай хамтын эзэмшлийн агуулах болон ногооны агуулах, Улаанбаатар хотод Дэвшилтэт технологийн өвлийн хүлэмж барих барилга угсралтын ажлын гэрээний гүйцэтгэл болон тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийг хангах зорилгоор, төсөл хэрэгжүүлэх хугацааг сунгах хүсэлтийг Азийн хөгжлийн банкинд хүргүүлж, хугацааг 6 сараар сунгуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Дархан-Уул аймгийн Орхон суманд "Хүнсний ногоо боловсруулах савлах цех барих ажил" 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд гүйцэтгүүлэхээр CW-06 дугаартай гэрээг Гээт ХХК-тай байгуулсан боловч, барилгын ажлын гүйцэтгэлийн тайланг ирүүлээгүй, гэрээт ажил бүрэн дуусаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Тус төсөл нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ДЭЗРҮЙН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,506,946,126.06	5,977,776,425.81
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,291,360,273.12	532,916,458.96
312	Банканд байгаа бэлэн мөнгө	1,291,360,273.12	532,916,458.96
3121	Төгрөг	53,458,796.13	57,768,737.43
31211	Төрийн сангийн харилцах	53,458,796.13	57,768,737.43
3122	Гадаад валют	1,237,901,476.99	475,147,721.53
31221	Төрийн сангийн харилцах	1,237,901,476.93.29	475,147,721.53
33	АВЛАГА	3,060,977.67	5,854,109.18
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,102,579.11	1,898,854.11
335	БУСАД АВЛАГА	1,958,398.56	3,955,255.06
3351	Байгууллагаас авах авлага	1,948,398.53	2,116,932.53
3352	Хувь хүмүүсээс авах авлага	10,000.03	1,838,322.53
36	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	3,212,524,875.27	5,439,005,857.67
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	3,212,524,875.27	5,439,005,857.67
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	45,885,084.89	16,320,279.55
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	45,885,084.89	16,320,279.55
392	Биет хөрөнгө	45,885,084.89	16,320,279.55
39203	Авто-тээврийн хэрэгсэл	156,079,616.00	156,079,616.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(118,774,167.11)	(144,787,436.45)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	49,481,720.00	49,481,720.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(47,007,634.00)	(49,481,720.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,774,500.00	10,774,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,668,950.00)	(5,746,400.00)
393	Биет бус хөрөнгө	0.00	0.00
39301	Программ хангамж	10,000,000.00	10,000,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(10,000,000.00)	(10,000,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,552,831,210.95	5,994,096,705.36
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,137,120.02	576,532,241.02
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,137,120.02	576,532,241.02
413	Өглөг	4,137,120.02	576,532,241.02
4136	Бусад өглөг	4,137,120.02	576,532,241.02
41361	Байгууллагад өгөх өглөг	0.00	572,395,321.00
41362	Хувь хүмүүст өгөх өглөг	4,136,920.00	4,136,920.00
41364	НДШ-ийн өглөг	200.02	0.02
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,548,694,090.93	5,417,564,464.34
512	Хуримтлагдсан үр дүн	4,548,694,090.93	5,417,564,464.34
51210	Өмнөх үеийн үр дүн	3,889,400,433.99	4,548,694,090.93
51220	Тайлант үеийн үр дүн	659,293,656.94	868,870,373.41
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,552,831,210.95	5,994,096,705.36

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	937,313,656.06	1,154,120,043.88
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	923,813,656.06	1,154,120,043.88
120	Нийтлэг татварын бус орлого	78,255,058.40	66,414,808.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	78,255,058.40	66,414,808.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	131,113.00	133,963.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	78,123,945.40	66,280,845.50
122	Тусламжийн орлого	845,558,597.66	1,087,705,235.38
122002	Хандив тусламж /гадаад/	845,558,597.66	1,087,705,235.38
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,500,000.00	0.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	13,500,000.00	0.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	13,500,000.00	0.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	271,779,536.26	282,523,852.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	271,779,536.26	282,523,852.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	271,779,536.26	282,523,852.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	117,678,260.87	134,965,000.00
210101	Үндсэн цалин	117,678,260.87	134,965,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,709,782.61	16,870,625.00
210201	Тэтгэврийн даатгал	14,709,782.61	16,870,625.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,200,000.00	38,400,000.00
210304	Байрны түрээс	43,200,000.00	38,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,087,415.84	10,426,550.49
210401	Бичиг хэрэг	1,125,808.81	249,500.00
210402	Тээвэр, шатахуун	2,703,807.00	4,465,429.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,257,800.03	39,807.03
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	5,671,814.46
2107	Томилолт, зочны зардал	8,386,000.00	7,613,000.00
210702	Дотоод албан томилолт	8,386,000.00	7,613,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,731,013.61	44,683,871.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,804,137.67	18,607,377.81
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	23,500,000.00	25,750,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	324,882.94	157,011.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	2,015,600.00	0.00
210813	Бусад зардал /ТӨҮГ/	86,393.00	169,483.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,987,063.33	29,564,805.33
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,987,063.33	29,564,805.33
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	665,534,119.80	871,596,191.25
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	21.81	580,593.67
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	21.81	580,593.67
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,240,484.67	3,306,411.51
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	6,240,484.67	3,306,411.51
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(6,240,462.86)	(2,725,817.84)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	659,293,656.94	868,870,373.41

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	859,108,597.66	1,087,705,235.38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	845,608,597.66	1,087,705,235.38
120	Нийтлэг татварын бус орлого	50,000.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	50,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,000.00	0.00
122	Тусламжийн орлого	845,558,597.66	1,087,705,235.38
122002	Хандив тусламж /гадаад/	845,558,597.66	1,087,705,235.38
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,500,000.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	224,353,499.10	252,296,207.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	224,353,499.10	252,296,207.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	224,353,499.10	252,296,207.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	117,990,089.54	137,589,797.50
210101	Үндсэн цалин	117,990,089.54	137,589,797.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,709,782.61	16,870,625.00
210201	Тэтгэврийн даатгал	14,709,782.61	16,870,625.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,500,000.00	36,000,000.00
210304	Байрны түрээс	40,500,000.00	36,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,871,108.84	4,784,807.03
210401	Бичиг хэрэг	1,125,808.81	245,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,487,500.00	4,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,257,800.03	39,807.03
2107	Томилолт, зочны зардал	4,770,000.00	7,600,000.00
210702	Дотоод албан томилолт	4,770,000.00	7,600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,512,518.11	49,450,978.17
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,213,242.17	18,560,847.81
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	20,000,000.00	25,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	324,882.94	157,011.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,888,000.00	0.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	86,393.00	169,483.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	0.00	5,563,636.36
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	634,755,098.56	835,409,027.68
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	468,853,641.00	1,591,127,024.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	468,853,641.00	1,591,127,024.00
2200	Дотоод эх үүсвэрээр	468,853,641.00	1,591,127,024.00
223001	Бусад хөрөнгө	468,853,641.00	1,591,127,024.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(468,853,641.00)	(1,591,127,024.00)
14	Бусад эх үүсвэр	21.81	580,593.67
145004	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	21.81	580,593.67
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	6,240,484.67	3,306,411.51
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	6,240,484.67	3,306,411.51
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(6,240,462.86)	(2,725,817.84)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	159,660,994.70	(758,443,814.16)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,131,699,278.42	1,291,360,273.12
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,291,360,273.12	532,916,458.96

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	3,889,400,433.99	3,889,400,433.99
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	3,889,400,433.99	3,889,400,433.99
Тайлант үеийн үр дүн		659,293,656.94	659,293,656.94
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	4,548,694,090.93	4,548,694,090.93
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	4,548,694,090.93	4,548,694,090.93
Тайлант үеийн үр дүн	-	868,870,373.41	868,870,373.41
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	5,417,564,464.34	5,417,564,464.34

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,621,914,945.00	1,843,423,231.70	778,491,713.30	70.3
УРСГАЛ ЗАРДАЛ	717,365,500.00	252,296,207.70	465,069,292.30	35.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	717,365,500.00	252,296,207.70	465,069,292.30	35.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	133,146,000.00	137,589,797.50	(4,443,797.50)	103.3
Үндсэн цалин	133,146,000.00	137,589,797.50	(4,443,797.50)	103.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,643,250.00	16,870,625.00	(227,375.00)	101.4
Тэтгэврийн даатгал	16,643,250.00	16,870,625.00	(227,375.00)	101.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,000,000.00	36,000,000.00	-	100.0
Байрны түрээс	36,000,000.00	36,000,000.00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	20,250,000.00	4,784,807.03	15,465,192.97	23.6
Бичиг хэрэг	3,000,000.00	245,000.00	2,755,000.00	8.2
Тээвэр, шатахуун	15,000,000.00	4,500,000.00	10,500,000.00	30.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,250,000.00	39,807.03	2,210,192.97	1.8
Томилолт, зочны зардал	30,000,000.00	7,600,000.00	22,400,000.00	25.3
Дотоод албан томилолт	30,000,000.00	7,600,000.00	22,400,000.00	25.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	464,226,250.00	49,450,978.17	414,775,271.83	10.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	394,226,250.00	24,124,484.17	370,101,765.83	6.1
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	70,000,000.00	25,000,000.00	45,000,000.00	35.7
Тээврийн хэрэгслийн татвар		157,011.00	(157,011.00)	
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		169,483.00	(169,483.00)	
Бараа үйлчилгээний бусад зардал	17,100,000.00	-	17,100,000.00	0.0
Бараа үйлчилгээний бусад зардал	17,100,000.00	-	17,100,000.00	0.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,904,549,445.00	1,591,127,024.00	313,422,421.00	83.5
Дотоод эх үүсвэрээр	1,904,549,445.00	1,591,127,024.00	313,422,421.00	83.5
Барилга байгууламж	1,904,549,445.00	1,591,127,024.00	313,422,421.00	83.5
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,621,914,945.00	1,843,423,231.70	778,491,713.30	70.3
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	2,621,914,945.00	1,843,423,231.70	778,491,713.30	70.3
Хандив тусламж /гадаад/	2,621,914,945.00	1,843,423,231.70	778,491,713.30	70.3
Төсвийн гүйцэтгэлийн тохируулга		(758,443,814.16)		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,291,360,273.12		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		532,916,458.96		
Төсвийн бусад мэдээлэл				
Ажиллагсдын тоо	2	2		100.0
Удирдах ажилтан	1	1		100.0
Гүйцэтгэх ажилтан	1	1		100.0

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 1 зөрчил¹ илэрснээс, зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүллээ.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Дархан-Уул аймгийн Орхон суманд "Хүнсний ногоо боловсруулах савлах цех барих ажил" 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд гүйцэтгүүлэх CW-06 дугаартай гэрээг Гээт ХХК-тай байгуулсан боловч, барилгын ажлын гүйцэтгэл тайланг ирүүлээгүй, гэрээт ажил бүрэн дуусаагүй байна.	1	-			1	-							
Дүн	1	-			1	-							

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.